


ДОТООДЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн үнэлгээ, индекс

Энэ сард зах зээлийн үнэлгээ 1.29 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 295.4 тэрбум төг буюу 18.6 хувиар буурлаа. MSE all индекс 962.4 бөгөөд өмнөх сараас 0.3 хувиар буурсан байна.



Компаниудын зах зээлийн үнэлгээнд эзлэх хувь

Энэ сард нийт 208 компаниас топ 5-д АПУ 265.3 тэрбум төгрөг, Тавантолгой 184.33 тэрбум төгрөг, Говь 69.4 тэрбум төгрөг, Багануур 57.8 тэрбум төгрөг, Шивээ овоо 55 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй орж байна.


Компаниудын 33Y-нд эзлэх хувь



Хувьцааны арилжааны үнийн дүн

Энэ сард хувьцааны арилжааны үнийн дүн 0.62 тэрбум төгрөг бөгөөд өмнөх оны мөн үеэс 1.64 тэрбум төгрөг буюу 3.6 дахин буурсан байна. МХБ-ийн нийт арилжаанд хувьцаа 1 хувь, ЗГҮЦ-ны арилжаа 99 хувь эзэлж байна.


Арилжааны үнийн дүн /тэрбум.төг/



Нийт хийгдсэн хэлцлийн тоо

Энэ сард нийт 958 хэлцэл хийгдсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэлцлийн тоо 67 буюу 7.5 хувиар өссөн байна.


Нийт хийгдсэн хэлцлийн тоо



Үнэт цаас нь арилжигдсан компанийн тоо

Энэ сард үнэт цаас нь арилжигдсан компанийн тоо 79 байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 компаниар өссөн байна.

Үнэт цаас нь арилжигдсан компанийн тоо



Нийт арилжаанд идэвхитэй арилжигдсан үнэт цаасны эзлэх хувь

Энэ сард нийт 71 компанийн хувьцаа арилжаалагдсанаас топ 5-д БиДиСек 152.1 сая төгрөг, АПУ 120.7 сая төгрөг, Ремикон 111.4 сая төгрөг, Ган Хэрлэн 82.0 сая төгрөг, Мах импекс 15.6 сая төгрөгийн хувьцаа арилжаалсан байна.


Идэвхитэй арилжигдсан үнэт цаас



Засгийн газрын үнэт цаасны арилжаа

Энэ сард ЗГҮЦ-ны арилжаа 82.56 тэрбум төгрөгийн арилжаалагдсан бөгөөд үүнээс МХБ 40 хувийг, Монголбанк 60 хувийг нь арилжаалсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт арилжааны үнийн дүн 39.5 тэрбум төгрөг буюу 32.4 хувиар буурсан байна.

Засгийн газрын үнэт цаасны арилжаа /тэрбум.төг/




АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

Жолоочийн албан журмын даатгал

Энэ сард жолоочийн албан журмын даатгалын хураамжийн орлого 1.92 төгрөг, нөхөн төлбөр 0.23 тэрбум төгрөг бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хураамжийн орлого 41 хувь өсч, нөхөн төлбөр 79 хувь буурсан байна.


Жолоочийн албан журмын даатгал /тэрбум.төг/



Зах зээлд эзлэх хувь

Энэ сард албан журмын даатгалын хураамжийн орлогоор 5 топ компанид Миг даатгал 300.3 сая төгрөг, Бодь даатгал 292.8 сая төгрөг, Монгол даатгал 262.5 сая төгрөг, Мандал даатгал 177.4 сая төгрөг, Монре даатгал 162.7 сая төгрөгийн орлоготой байна.

Даатгалын компанийн зах зээлд эзлэх хувь




Тайлбар: 2015.09.31 өдрийн мэдээ болно.

БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Арилжааны үнийн дүн

Энэ сард ХААБ-ын арилжааны үнийн дүн 14.8 тэрбум төгрөг байсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 936.8 сая төгрөг буюу 6 хувь буурсан байна.


Арилжааны үнийн дүн /тэрбум.төг/



Биелсэн хэлцлийн тоо

Энэ сард ХААБ дээр биелсэн хэлцлийн тоо 83 байсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэлцлийн тоо 16 буюу 24 хувь өссөн байна.


Биелсэн хэлцлийн тоо



Зах зээлд
ээлэх хувь

Энэ сард ХАА-н биржийн арилжаанд нийт 8 брокерын компани оролцсоноос эхний 3-д Танандээж 6.4 тэрбум төгрөг, Хаантэлмэн 2.9 тэрбум төгрөг, Цэц-Инвест 6.4 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна.

ХАА-н брокерын компаниудын зах зээлд эзлэх хувь




ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Зээлийн
батлан
даалт

Энэ сард зээлийн батлан даалт авах 1.03 тэрбум төгрөгийн 10 хүсэлт ирснээс 85.6 хувь буюу 0.883 тэрбум төгрөгийн 7 хүсэлтийг олгохоор шийдвэрлэсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45 хувь буурсан байна.

Тайлбар: Зөвхөн ЗБДС-аас олгохоор шийдвэрлэсэн батлан даалтын хэмжээ болно.

Зээлийн батлан даалтын хэмжээ /тэрбум.төг/




Эх сурвалж: СЗХ-ны зохицуулалтын байгууллагууд

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2015 оны эхний хагас жилд 7047.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 205.6 тэрбум төг буюу 3.0 хувиар өслөө. Үүнд: ХАА-н салбар 9.4 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 12.1 хувь, үйлчилгээний салбар 0.3 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. ДНБ, оны үнээр 2015 оны эхний хагас жилд 10690.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 771.2 тэрбум төг буюу 7.8 хувиар өслөө.


ДНБ-ий өсөлт, хувиар
(үйлдвэрлэлийн арга, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх оны мөн үеийнхээс)



Төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2015 оны эхний 9 сард 4045.9 тэрбум төг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 4913.2 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 867.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 674.8 тэрбум төгрөгөөр өсөхөд зарлагын өсөлт нь орлогын өсөлтөөс 15.3 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төг




Гадаад худалдаа

Нийт бараа эргэлтийн хэмжээ 2015 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеийнхээс 1646.2 сая ам.дол буюу 20.5 хувиар буурчээ. Үүнд:

Экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 11.9 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний экспорт 552.4 сая ам.дол, нэхмэл бүтээгдэхүүнийх 30.5 сая ам.дол-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Импортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 29.0 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний импорт 371.7 сая ам.дол, авто, агаар, усан замын тээврийн эд ангийнх 218.9 сая ам.дол, машин тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл тэдгээрийн эд ангийнх 195.4 сая ам.дол-аар буурсан нь голлон нөлөөлжээ.


Гадаад худалдааны нийт бараа эргэлт, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, сая ам.долл



Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 2015 оны 9 дугаар сард өмнөх сараас 0.8 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 4.9 хувиар өслөө. Үүнд: Хувцас, бөс бараа, гутлын бүлэг, боловсролын үйлчилгээний бүлэг, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.



Хэрэглээний үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар = 100)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

МӨНГӨНИЙ ТОЙМ



Мөнгөний нийлүүлэлт



Мөнгөний нийлүүлэлт 2015 оны 9 дүгээр сард 9934.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.3 хувь, өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурчээ. Тус 1.4 хувиар буурсны 3.4 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -0.3 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, -0.9 нэгж хувийг төгрөгийн харилцах, -1.3 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -2.2 нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлсэн байна.

Мөнгөний нийлүүлэлтийн 52.2 хувийг төгрөгийн хадгаламж, 21.1 хувийг валютын хадгаламж, 12.1 хувийг төгрөгийн харилцах, 10.5 хувийг валютын харилцах, 4.1 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.

Зээл, зээлийн хүү



Арилжааны банк, ХЗХ-оос олгосон зээл өмнөх сарынхаас 0.8 хувь буюу 97.7 тэрбум төгрөгөөр өсч, өнгөрсөн оны мөн үеэс 5.3 хувь буюу 673.1 тэрбум төгрөгөөр буурч 11.9 их наяд төгрөгт хүрсэн байна. МИК ОССК-д шилжүүлсэн зээлийг оруулж тооцвол зээлийн үлдэгдэл 13.7 их наяд төгрөг байна.


Нийт зээлийн 53.8 хувь нь хувийн хэвшил, 44.6 хувь нь иргэд, 1.5 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна. МИК-д шилжсэн ипотекийн зээлийг нийт зээлийн үлдэгдэлд оруулж тооцвол 46.9 хувь нь хувийн хэвшил, 51.7 хувь нь иргэдэд олгосон зээл байна.

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2015 оны 9 дүгээр сард өнгөрсөн оны мөн үеэс 0.9 нэгж хувиар өсч жилийн 13.01 хувь болов. Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өсч жилийн 18.73 хувь, гадаад валютынх өмнөх оны мөн үеэс 3.3 нэгж хувиар буурч жилийн 10.5 хувь болжээ. Харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өөрчлөлт бага байв.

Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2015 оны 9 дүгээр сарын эцэст 1996.83 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 155.9 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 1993.79 төгрөг байв.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш, 2010.12.31=100




ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Орон сууцны үнийн индекс

Тухайн 9 дүгээр сард орон сууцны үнийн индекс 2013 оны 1 дүгээр сарыг суурь болгон тооцсоноор 1.09, өөрчлөлт нь сарынх -2.2, оны эхнээс -8.1, жилийнхээс -11.1 хувь тус тус байлаа.

Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ нь 2015 оны 9 дүгээр сарын байдлаар 2,047,000 төгрөг болж өмнөх сараас 1.6%, өнгөрсөн оны мөн үеэс 3.0%-иар буурсан байна.

Орон сууцны үнийн индекс



Орон сууцны зээл



Тухайн сард олгосон зээл



Тухайн 9 дүгээр сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 28.5 хувиар өссөн ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.0 хувиар буурсан байна.

Тус сард шинээр олгосон зээлийн 75.2 хувь буюу 58.8 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 24.8 хувь буюу 19.4 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна

Тухайн сард олгосон зээлийн 59.9 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 68.2 хувь нь 16-20 жил, 19.0 хувь нь 11-15 жил, 10.7 хувь нь 6-10 жил, 2.1 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.

Тайлбар: ОСИСТТБХ -“Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Эдийн засгийн өсөлт

Бодит ДНБ-ийн жилийн өсөлт тус графикт 2012 оноос хойш Хятад улс буурч байхад бусад нь өсөх хандлагатай байна.
Хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн өсөлтөөс хөгжингүй орнуудын өсөлт илүү хурдтай байх хандлагатай байна.



Инфляц

Жилийн инфляц тус графикт 2012 оноос хойш дэлхийн хандлага буурч байхад Хятад, ОХУ-д өсөх хандлагатай байна.
Хөгжиж байгаа орнуудын жилийн инфляцийн бууралтаас хөгжингүй орнуудын инфляц илүү хурдтай буурах хандлагатай байна.




Экспорт, импортын өсөлт

2015 онд дэлхийн цэвэр экспорт хасах гарах бол зүүн азийн цэвэр экспорт нэмэх гарах хандлагатай байна.
Дэлхийн экспорт, импортын өсөлтөөс Зүүн азийн өсөлт илүү байх хандлагатай байна.




Валютын ханш

2015 оны 9 дүгээр сарын тухайн улсын валютын ханшийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад евро 14 хувь, рубль 76 хувь, иен 12 хувь, юань 4 хувь, төгрөг 9 хувь өссөн байна.
2015 оны 9 дүгээр сарын тухайн улсын валютын ханшийг өмнөх сартай харьцуулахад евро 1 хувь, иен 2 хувь буурч, юань 1 хувь, төгрөг 0.2 хувь, рубль 2 хувь өссөн байна.



Металлын ханш

2015 оны 9 дүгээр сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 трой унц /31.1 гр / алт 9 хувь, цагаан алт 29 хувь, мөнгө 20 хувь үнэ буурсан байна.
2015 оны 9 дүгээр сарыг өмнөх сартай харьцуулахад 1 трой унц алт 0.6 хувь өсч, цагаан алт 2 хувь, мөнгө 1.3 хувь үнэ буурсан байна.



Түлшний ханш

2015 оны 9 дүгээр сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад сая тонн нүүрс Австралид 18 хувь, сая тонн байгалийн хий Америкт 32 хувь, Европт 27 хувь, Японд 41 хувь буурсан байна.



Эх сурвалж: Дэлхийн банк, ОУВС, НҮБ